

# Нийгмийн тухай мэдлэг

**БАГШ:Д.ОЮУН**

# Сэдэв 3: Нийгмийн шилжилт хөдөлгөөн

Сэдвийн зорилго:

Нийгмийн шилжилт хөдөлгөөн болон иргэний нийгэм түүний гол шинжүүдийн талаар цэгцтэй мэдлэг олгох. Мөн нийгмийн харилцаа, харилцааны ангилалын тухай мэдлэг олж авахад оршино.

# Түлхүүр үгс:

- Нийгмийн шилжилт хөдөлгөөн
- Иргэний нийгэм
- Нийгмийн харилцаа
- Харилцааны объект
- Харилцааны субъект
- Нийгмийн амьдралын хүрээ

# НИЙГМИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Нийгмийн давхраажилтын бүтэц, хувь хүн, нийгмийн бүлэг ямар байр суурь эзэлж буй, тэдгээрийн нийгмийн статус нь яаж өөрчлөгдөж байгаа зэргээр тодорхойлогддог хүмүүсийн нийгмийн байр суурийн өөрчлөлтийн цогц юм.

Нийгмийн хөдөлгөөнт цаг хугацааны хувьд хэдэн жилийн турш эсвэл хэдэн арван жилийн турш үргэлжилдэг.

Нийгмийн социаль шилжих хөдөлгөөн нь хоёр гол үзүүлэлтийн тусламжтайгаар өөрчлөгддөг . Энэ нь:

- шилжих хөдөлгөөний эзэлхүүн
- шилжих хөдөлгөөний зай завсар юм.

Шилжих хөдөлгөөний эзэлхүүн нь хувь хүн ба нийгмийн давхрааны тоо босоо чиглэлд гарч буй өөрчлөлт, өөрчлөлтийн хоорондын цаг хугацаагаар тодорхойлогдоно.

Шилжих хөдөлгөөний зай завсар нь хувь хүн, нийгмийн бүлэг ямар шатанд дэвших буюу доошилсныг илэрхийлсэн үе шатны тоон үзүүлэлт юм.

Нийгэм дэхь шилжилт хөдөлгөөнийг тухайн хүний нийгэмд эзэлж буй байр сууриас нь хамааруулаад үе доторх ба үе хооронд гэж ангилдаг.

Шилжилт\migration\ - хүмүүс оршин суугаа газраа өөрчлөх, өөр нутаг дэвсгэрт шилжих явдал юм.

Хүн амын шилжилтийг:

- Нутаг дэвсгэр хоорондын
- Суурин хоорондын хэмээн 2 ангилдаг.

Шилжилт нь угсаатны үйл ажиллагаа, хүн амын нөхөн үржихүй, хэл, соёл, социал хөдөлгөөнд маш их нөлөөтэй байдаг.

# Нийгмийн социал шилжилт хөдөлгөөн

## Нийгмийн шилжих хөдөлгөөний ангилал



# Нийгмийн шилжих хөдөлгөөний төрөл, хэлбэр, ангилал

Үеийн доторх шилжилт:	Хувь хүний нийгмийн байр суурийг эцэг эхтэй нь харьцуулдаггүй.
Үе хоорондын шилжилт:	Эцэг эхтэйгээ харьцуулахад үр хүүхэд нь нийгмийн илүү өндөр, эсвэл доод шатны суурьт шилжих
Хэвтээ шилжилт:	Давхраажилтын зэрэг зиндаа адилхан бүлэг давхраанд шилжиж буй шилжилт
Босоо шилжилт:	Давхраажилтын зэрэг зиндаа нь дээшлэх юмуу доошлох бүлэг давхраанд шилжиж буй шилжилт
Хувь хүний шилжих хөдөлгөөн:	Тодорхой хүний нийгмийн байр суурь өөрчлөгдөхийг харуулдаг
Бүлгийн шилжих хөдөлгөөн:	Тухайн давхрааны статус өөрчлөгдөх тохиолдолд хамт олноороо хөдөлгөөнд орох явдал.
Маргинал хөдөлгөөн:	Нийгмийн давхрааны дээд, доод түвшний зааг дээр байгаа нөхцөлийг хэлнэ. Угсаатны, Био, Улс төрийн, Эдийн засгийн, Шашны, Гэмт хэргийн гэж ангилна

# Хувь хүн, нийгмийн бүлгийн маргинал хөдөлгөөн

Хоёр нийтлэг, эсвэл хоёр соёлын зааг дээр оршин буй хувь хүн ба нийгмийн бүлгийн тодорхойгүй нөхцөл байдлыг маргинал(marginelis- зааг хил хязгаар дээр орших) гэдэг.

Нийгмийн өөрчлөлтийн улмаас сэтгэл зүйн хямралд орж өөрсдийгөө хоёрдмол байдлаар ухамсарласан хүмүүсийг маргиналууд гэдэг.

Маргинал гэдэгт :

- Угсаатны маргинал
- Биомаргинал
- Социомаргинал
- Улс төрийн маргинал
- Эдийн засгийн маргинал
- Шашны маргинал
- Гэмт хэргийн маргинал ... зэрэг нийгмийн бүтцэд эзлэх байр суурь нь тодорхойгүй байгаа бүхнийг багтааж болно.





# ИРГЭНИЙ НИЙГЭМ

Хувийн эрх ашгийг удирдлага болгодог, төрөөс үл хамаарах нийгмийн институт ба бие хүмүүсийн хоорондын харилцааны систем мөн.

## Гол шинжүүд


Хүмүүс харьцангуй бие даасан, автономи байдалтай амьдардаг байх

Хувь хүн, бүлгийн хэрэгцээ сонирхол, эрх ашгийн олон янз байдлыг хүлээн зөвшөөрдөг байх

Иргэний нийгмийн байгууллагууд аяндаа ( өөрөө ) үүсч хөгждөг, өөрийгөө удирдан зохион байгуулж чаддаг байх

Төр болон нийгмийн байгууллагууд иргэдийн амьдрал, үйл ажиллагаанд үл оролцогч шинжтэй байх

Орчин үеийн нийгэм, иргэншилд зуршмал байдаг үнэт зүйлсийг мөрддөг байх



# Нийгмийн харилцаа





# НИЙГМИЙН ХАРИЛЦАА

Хүний амьдралын асуудлуудыг шийдвэрлэдэг, тогтвортой дахин давтагддаг, тухайлан хэлбэржсэн харилцааг нийгмийн харилцаа гэнэ.

## Харилцааны объект:

Хэрэгцээ, үйлдвэрлэл, өмч хөрөнгө, эрх мэдэл, үүрэг хариуцлага гэх мэт субъектуудыг холбож байгаа сэдэл шалтгаан зэрэг

## Харилцааны субъект:

Хувь хүн, бүлэг, нийгмийн бүтцийн элемент, зохион байгуулалтын хэлбэр (нам, төр төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж) улс үндэстэн, бүс нутгийн болон олон улсын байгууллага гэх мэт.

# НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ АНГИЛАЛ

Нийгмийн харилцаа нь тодорхой орчин нөхцөлд, орон зайд явагдах бөгөөд түүнийг нь үндэслэн ангилж болно.	Бие хүн хоорондын
	Байгууллага, бүлэг, нийтлэг хоорондын
	Институт хоорондын
	Нийгэм хоорондын

## НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ХЭЛБЭРҮҮД

**Шинэтгэл:** Нийгмийн амьдралд байгалийн жамаар болдог, аажим дэс дараалалттай өөрчлөлт


**Хувьсгал:** Нийгмийн амьдралд үндсэн эргэлт гаргадаг, харьцангуй хурдтай, чанарын гүнзгий өөрчлөлт.

**Шинэчлэл:** Тодорхой хугацаанд нийгмийн амьдралын аль нэг талыг хувиргах, өөрчлөн зохион байгуулахад чиглэсэн иж бүрэн үйл ажиллагаа.

# Нийгэм нь эдийн засаг, улс төр, социал, оюун санаа, эрх зүй зэрэг нийгмийн амьдралын үндсэн хүрээнүүдээс бүрэлдсэн бүхэллэг ТОГТОЛЦОО ЮМ.

Эдийн засгийн амьдралын хүрээ	Хүний анхдагч хэрэгцээ болох хоол хүнс, орон байрны хэрэгцээг хангахаас эхлээд үйлдвэрлэл, хөдөлмөрийн үйл ажиллагааны олон үзэгдэл, үйл явцыг хамаардаг.
Улс төрийн амьдралын хүрээ	Нийгмийн амьдрал, үйл ажиллагааны салшгүй хэсэг, харьцангуй биеэ даасан тогтолцоо, нийгмийг хөдөлгөөнд оруулдаг өөрчлөн байгуулах гол хүч, хэрэгсэл юм
Социал амьдралын хүрээ	Бие хүн, социал нийтлэгүүд, социал бүлгүүд, тэдгээрийн хоорондын харилцаа, социал бодлого, социал үнэт зүйлс зэрэг олон үзэгдлийг өөртөө багтаадаг.
Оюун санааны амьдралын хүрээ	Нийгмийн оюун санааны зүйлийг бий болгох, хадгалах, хэрэглэх, өвлүүлэх үйл ажиллагаа, тэдгээрийг эрхлэх төрөлжсөн байгууллагуудыг бүхэлд нь хамаарна
Эрх зүйн амьдралын хүрээ	Эрх зүй, эрх зүйн харилцаа, эрх зүйн ухамсар, эрх зүйн бодлого, хууль ёс, эрх зүйн хэм хэмжээтэй холбоотой олон талт харилцаа, үзэгдлүүдийг өөртөө хамаарна.

Зорилгогүй мэргэн ухаан төрөөлдөнө. Хаа сайгүй байна гэдэг нь хаана ч байхгүй гэсэн үг. \Монтень\



# Нийгэмшилтийн тухай

Нийгэмшил гэдэг нь хүнээс тухайн нийгэмд амжилттай үйл ажиллагаа явуулхад хэрэг болохуйц зан төлөвийн шинж, нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлсийг олж авах үйл явц юм.

Хүн төрөлхтөн бид нийгэм хэмээх онцгой ёс журамтай, бие биенээсээ харилцан хамааралтай амьдардаг бөгөөд орь ганцаар насан туршдаа амьдарч биеийн болоод сэтгэл зүйн хэрэгцээгээ хангаж чадахуйц амьтан биш учир ярьж сурахаас авахуулаад олон чадваруудыг эзэмших шаардлагатай болдог нь нийгэмшилт юм.



# Нийгэмшилтийн тухай

Нийгэмд хүний ёсоор амьдрахад зайлшгүй шаардлагатай эдгээр чадвар, дадал, ухаарлуудыг бид ямар нэг сургалтад сууснаар, эсвэл хэн нэгэн хүнээс зөвлөгөө авсанаар бүгдийг өөрийн болгох боломжгүй. Харин насан туршдаа дэлгүүр орж худалдан авалт хийх, найз нөхөдтэйгөө сэтгэлээ уудлан ярилцах, эцэг эхдээ хайрлуулж үнсүүлэх зэрэг бүхий л бидний хийдэг үйл ажиллагаа, үйл хөдлөл, бусадтай харилцах харилцаагаар нийгэмшилт явагддаг.



*Хүн хэрхэн нийгмийн гишүүн болдог өөрөөр хэлбэл хэрхэн нийгэмшдэг талаар олон төрлийн тайлбар, онолууд байдаг. Тухайлбал:*

- ❖ Бие хүний хөгжлийн онол \Ч.Х.Кули\ - Хүмүүс орчин ертөнцтэй ихээхэн харилцан үйлдсэний үндсэн дээр төлөвшдөг. Хүмүүс өөрсдийнх нь тухай бусад хүмүүс юу бодож байгаа тухай төсөөлөлдөө үндэслэн өөрсдийн үйл байдал, үйлдлээ тодорхойлдог болохыг Ч.Х.Кули “Толинд туссан би” гэдэг ойлголтоор илэрхийлсэн байдаг. Энгийнээр хэлбэл хүн бусадтай харилцсанаар бусдаас суралцаж, нийгэмд амьдрахад шаардлагатай чадваруудыг олж авдаг гэсэн үг юм.
- ❖ Психоанал итик онол З.Фрейд Хүнд төрөх сэрэл буюу хүсэл нь хүний соёлтой үйлдэлтэй зөрчилддөг. Нийгэмшилт бол тэрхүү сэдлийг хязгаарлагч юм. Тухайлбал, тухайн хүн их чихэр идмээр санагдах нь бидний хүсэл харин их чихэр идэж болохгүй, их идсэнээр таргалж, шүд хорхой иднэ хэмээн их чихэр идэхийг хязгаарлах нь нийгэмшилт гэж буйгаар тайлбарлаж болно. Тодорхой хэм хэмжээг дагах замаар хүн нийгэмшдэг.

## Нийгэмшилтэд дараах 3 хүчин зүйл нөлөө үзүүлдэг.

- Макро хүчин зүйл: Улс орны нийгмийн нөхцөл, улс үндэстэн юуг эрхэмлэн үзэж буй байдал, нийгэм, улс төрийн амьдрал хувь хүний нийгэмшилтэд нөлөө үзүүлдэг.
- Мезо хүчин зүйл: Үндэстэн угсаатны онцлог, ёс заншил, амьдарч байгаа газар, орон нутаг, суурин хэв маяг, олон нийтийн мэдээллийн сүлжээ зэрэг нь 19 хүмүүсийн нийгэмшилтэд нөлөөлдөг.
- Микро түвшинд: Хүмүүстэй шууд харилцан үйлчлэлд оролцож, нийгэмшилтэд нөлөөлж байдаг хүчин зүйлс буюу гэр бүл, найз нөхдийн хүрээлэл нь мөн хүний нийгэмшилтэд нөлөө үзүүлдэг байна.



Нийгэмшилтийг тодорхойлох гол шалгуур:

- ❖ Бусдыг хүндэтгэдэг байх
- ❖ Хүрээлэн буй орчноо хайрладаг байх
- ❖ Өөрийн гэсэн үнэт зүйл, үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх
- ❖ Ухаалаг шийдвэр гаргаж чаддаг байх зэрэг болно



# БИЕ ХҮНИЙ НИЙГМИЙН ҮҮРЭГ.

Бие хүн нийгэмд дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд :

**Бие хүн хөдөлмөрлөгч үйлдвэрлэгч-** хүний энэ үүрэг нь нийгэмд гол шийдвэрлэгч ач холбогдолтой бөгөөд үүнийхээ үрээр оюуны болон материаллаг баялагийг бүтээн бий болгож, өөрийгөө болоод нийгмээ хөгжүүлж байдаг.

**Бие хүн өмчлөгч-** хүн эд баялаг хийгээд оюуны, биеийн хүчийг өөртөө өмчлөн эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж байдаг. Хүний өмчлөх эрхийг хуулиар зохицуулдаг.

**Бие хүн хэрэглэгч-** хүн нийгмийн баялгийг бүтээн бий болгож хэрэгцээгээ хангаснаар энэ үүрэг нь биелэгдэнэ. Нөөц баялаг хязгаартай тул хүн ямагт сонголтийн өмнө зогсож, хэрэглээгээ зохицуулж байдаг.



# БИЕ ХҮНИЙ НИЙГМИЙН ҮҮРЭГ.

Бие хүн нийгэмд дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд :

**Бие хүн, иргэн хүн-** нийгмийнхээ эд эс, гишүүн болж, харьяалагдаж, тодорхой эрх эдэлж, үүрэг гүйцэтгэн, бүлэг дотроо байр суурь эзэлж , нэр хүнд олж байдаг.

**Бие хүн ухамсартай, идэвхтэй хүн-** тэрээр дарлагдах байдалтайгаа үл эвлэрэх, эсвэл шударга бус зүйлийн эсрэг тэмцэх, улс төрийн амьдралд оролцох, олон нийтийн төлөө өөрийгөө зориулах, эсвэл хувийн сонирхлоор амьдрах зэрэг алив нэгэн аж төрөх ёсыг сонгож байдаг.

**Бие хүн, гэр бүлийн гишүүн-** энэ хувьдаа үр хүүхэд, эцэг эх, ах дүү нараа асарч хүмүүжүүлэн, нийгэмшүүлж, гэр бүлээ тэжээн тэтгэж, хүний нөхөн үйлдвэрлэл явуулж байгаагаар энэ үүрэг нь илэрнэ.



# Хяналтын асуулт, даалгавар:

1. Нийгэмшилтэд нөлөөлж буй хувь хүн бүлэг байгууллага нийгмийн тодорхой нөхцөлүүдийн цогцыг.....ГЭНЭ.

- А. Гэр бүл
- Б. Нийгэмшлийн агент
- В. Дахин нийгэмшилт
- Г. Адилсал

2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэдэн онд батлагдсан бэ?


- А.1948
- Б.1949
- В.1950
- Г.1951

3. Анхны үндсэн хууль хэдэн онд батлагдсан бэ?

- А.1921.11.26
- Б.1924.11.26
- В.1924.10.25
- Г.1925.03.01

# Эх сурвалж:

1. “Нийгэм судлал” хичээлийн ерөнхий боловсролын сурах бичгүүд
2. Д.Буян “Нийгмийн тухай мэдлэг”. УБ., 2011
3. Орчуулсан Б.Батчулуун “Философи”. УБ., 2012
4. О.Пүрэв, С.Нямзагд, Р.Дарьхүү, Г.Сайнхишиг, Д.Буян, Т.Алтанцэцэг “Нийгмийн ухаан”. УБ., 2012
5. Б.Амгаланбаяр, Т.Сайхнаа “Хичээлүүдийн лавлах”. УБ., 2014



**Анхаарал хандуулсанд баярлалаа.**

